

2013 ОНЫ 7 ДУГААР САРЫН ДААТГАЛЫН МЭДЭЭ

2013 оны 8 дугаар сарын 14

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2013 оны 7 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2013.07.01	Нэмэгдсэн	Хасагдсан	/тоогоор/ 2013.07.31
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	240			240
3	Даатгалын төлөөлөгч	3227	32 ¹	126 ²	3133
4	Даатгалын зуучлагч	20			20
5	Даатгалын хохирол үнэлэгч	11			11
6	Актуарч	15			15
7	Жолоочийн даатгалын зөвшөөрөл	16			16
8	Даатгалын зуучлагч компанийн салбар	36			36
9	Даатгалын компанийн төлөөлөгчийн газар	4	2 ³		6

¹Хорооны даргын 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 190 дүгээр тушаалаар “Монгол даатгал” ХХК-ийн 5 иргэнд, Хорооны даргын 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 199 дүгээр тушаалаар “Тэнгэр даатгал” ХХК-ийн 27 иргэнд тус тус даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг олгосон байна.

² Хорооны даргын 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 191 дүгээр тушаалаар “Монгол даатгал” ХХК-ийн 126 иргэний даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

³ Хорооны даргын 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 198 дугаар тушаалаар “Тэнгэр даатгал” ХХК-ийн Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт, Хорооны даргын 2013 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 201 дүгээр тушаалаар “Соёмбо даатгал” ХХК-д БНСУ-ын Сөүл хотод тус тус төлөөлөгчийн газар байгуулах шийдвэрлэсэн байна.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2013 оны 7 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг сарын болон өссөн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

Ердийн даатгалын компаниудын хувьд :

Үзүүлэлт	2013.07.31	/төгрөгөөр/ 2013.07.31
	/сарын дүн/ 6,407,939,862.72	/өссөн дүн/ 44,647,178,218.30
Даатгалын нийт хураамж		

Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж	999,703,303.99	9,062,972,571.93
Олгосон нийт нөхөн төлбөр	1,910,016,036.15	14,410,115,236.97
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	630,857,505.00	5,480,481,520.04
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	1,413.00	12,431.00
Давхар даатгалд төлсөн хураамж	1,767,847,473.85	10,131,580,095.86
Байгуулсан даатгалын гэрээний тоо	54,351.00	329,589.00
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо	16,645.00	166,311.00
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо	26,356.00	196,347.00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	57,600,800,000.00	488,139,112,208.00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр	72,110,601.34	2,127,339,467.00

2013 оны 7 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хураамжийн орлого 44647.2 сая төгрөг, үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж 9062.9 сая төгрөг, олгосон нөхөн төлбөр 14410.1 сая төгрөг ба үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 5480.5 сая төгрөг болсон байна. Эндээс даатгалын хохирол нөхөлтийн түвшин сарын байдлаар 20.6 хувь, өссөн дүнгээр 32.7 хувь болсон бөгөөд өмнөх сарын мөн үеийнхээс сарын байдлаар 9,2 пунктээр өсч, өссөн дүнгээр 0.4 пунктээр буурсан байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2013.07.31 /сарын дүн/	2013.07.31 /өссөн дүн/
Даатгалын нийт хураамж	97,158,956.00	576,217,355.00
Олгосон нийт нөхөн төлбөр	14,325,833.00	91,279,117.00
Давхар даатгалд төлсөн хураамж	4,103,285.00	33,627,365.00
Байгуулсан даатгалын гэрээний тоо	49.00	146.00
Хувь хүний хугацаат даатгалд	18.00	31.00
Байгууллагын хугацаат даатгалд	3.00	14.00
Өндөр хамгаалалттай ЭМД-д		0.00
Эмнэлгийн мөнгөний даатгалд	19.00	24.00
Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	3.00	22.00
Тэтгэврийн даатгалд	3.00	3.00
Орон сууцны даатгалд	2.00	2.00

Хуримтлалын даатгалд		0.00
Зээлдэгчийн амь насны даатгалд	1.00	17.00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	42,259,000.00	42259000.00

Урт хугацааны даатгагч 2013 оны 7 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ 576.2 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой, 91.3 сая төгрөгийг нөхөн төлбөрт олгосон байна. Даатгалын нөхөн олговрын түвшин 15.9 хувьтай байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2013.07.31 /сарын дүн/	2013.07.31 /өссөн дүн/
Нийт орлого	16,878,721,478.07	17,059,340,114.53
Даатгалын зуучлагчийн орлого	64,737,284.09	218,159,238.66
Үүнээс: Сайн дурын даатгал	63,474,461.39	192,577,837.50
Албан журмын даатгал	1,262,822.70	13,886,075.20
Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	86,957,885.75	344,199,519.17
Зуучилсан даатгалын гэрээний тоо	918.00	3,035.00
Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээ	80,176,800,000.00	80,176,800,000.00

2013 оны 7 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын зуучлагч компаниуд 218.1 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна. Үүний 88.1 хувийг сайн дурын даатгалаас үлдсэн хувийг албан журмын даатгалын хураамжийн орлогоос бүрдүүлсэн байна. “Ренессанс групп” ХХК-ийн зуучилсан гэрээ даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээтэй байна.

Даатгалын зуучлагч компаниудаас “Эм жи ай би” ХХК, “Пийс оф лайф” ХХК, “Жомолхари” ХХК, “Си эн эн икс” ХХК-иуд тус тус орлогогүй ажилласан байна.

“Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Изи инвестмэнт” ХХК, ХХК, “Нэйшнл эженси” ХХК тус тус 7 дугаар сарын мэдээг тус тус ирүүлээгүй байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2013.07.31 /сарын дүн/	2013.07.31 /өссөн дүн/
Нийт орлого	29,669,954.55	205,938,941.37
Даатгалын хохирол үнэлгээний орлого	17,463,817.92	92,334,190.10

Үүнээс: Сайн дурын даатгал	6,972,363.19	40,234,177.37
Албан журмын даатгал	10,491,454.73	52,100,011.73
Үнэлсэн даатгалын хохирлын тоо	1,122.00	6,598.00
Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	12,070,000.00	12,070,000.00

2013 оны 7 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хохирол үнэлэгч компаниуд 92.3 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Үүнээс 43.6 хувийг сайн дурын, 33.6 хувийг албан журмын даатгалын хохиролын үнэлгээний орлогоос төвлөрүүлсэн байна.

“Жи эй си си” ХХК, “Мега марз” ХХК, “Файн эстимэйт” ХХК-иуд тус тус 7 дугаар сарын мэдээг тус тус ирүүлээгүй байна.

БУСАД

Хорооны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 249 дүгээр тогтоолоор “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ыг шинэчлэн батлах тухай, Хорооны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 250 дугаар тогтоолоор “Ердийн даатгалын компанийн нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ыг батлах тухай Хорооны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 267 дугаар тогтоолоор “Акбар-Аудит” ХХК, “Интер-Аудит” ХХК-иудын даатгалын байгууллагад аудит хийх эрхийг тус тус түдгэлзүүлсэн шийдвэр гаргасан байна.

ДААТГАЛЫН ГАЗАР